ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ДГА-2023/47/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг
2023 он

| | |
|---|---|
| Дарга, тэргүүлэх аудитор: | Т.Ган-Өлзий |
| Утас: 70522734 | Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn |
| Аудитын менежер: | У.Оюунтулхуур |
| Утас: 70523020 | Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn |
| Аудитор: | Б.Ариунбаатар |
| | Цахим хаяг: Ariunbaatarb@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1.Хараат бус аудиторын дүгнэлт ..... 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 4
3.Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 11
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчин: ..... 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 13
4.Аудитын тайлан ..... 13
4.1 Ерөнхий зүйл ..... 13
4.2 Материаллаг байдал ..... 14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 15
5.Аудитын илрүүлэлт ..... 15
5.1 Залруулсан алдаа ..... 15
5.2 Албан шаардлага ..... 15
6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 16


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин |

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.20 № 1-6/81

танай______________-ны №______________-т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА У.ЭНХМАА
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь 2022 онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас мэдээлэл технологийн зардалд 13.5 сая төгрөг, шуудан холбооны зардал 52.5 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардлаас урсгал засварын зардалд 19.2 сая төгрөгийг, гэрэл цахилгааны зардлаас шатахууны зардалд 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулж нийт 33.7 сая төгрөгийн батлагдсан төсвийг зориулалтын бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна"* гэж заасантай нийцэхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

0100003[illegible]

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,773,465,907.26** | **1,606,290,334.59** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 769,410.33 | 292,759,537.86 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 769,410.33 | 292,759,537.86 |
| **3121** | **Төгрөг** | 769,410.33 | 292,759,537.86 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 609,642.01 | 292,759,537.86 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 159,768.32 | - |
| **33** | **АВЛАГА** | 967,399,791.82 | 3,530,762.35 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 467,972.00 | 272,126.00 |
| **335** | **Бусад авлага** | 966,931,819.82 | 3,258,636.35 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 966,931,819.82 | 3,247,461.78 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | 11,174.57 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 805,296,705.11 | 1,310,000,034.38 |
| **351** | **Түүхий эд материал** | 680,859,121.55 | 1,130,259,996.12 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 120,572,171.10 | 147,953,599.14 |
| 35130 | Эм боох материал | 560,286,950.45 | 982,306,396.98 |
| **354** | **Хангамжийн материал** | 124,437,583.56 | 179,740,038.26 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 777,905.00 | 406,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 325,800.00 | 358,127.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,681,500.00 | 8,245,111.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 9,309.00 | 19,384,309.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,447,541.99 | 2,589,442.69 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 119,195,527.57 | 148,757,048.57 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **11,150,390,550.49** | **13,123,459,338.94** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 11,150,390,550.49 | 13,123,459,338.94 |
| **392** | **Биет хөрөнгө** | 10,916,390,550.49 | 12,889,459,338.94 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 8,840,002,971.03 | 8,840,002,971.03 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (156,076,862.59) | (310,120,956.79) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 416,447,037.15 | 385,536,434.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (126,003,195.60) | (164,748,664.73) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 2,976,615,322.83 | 5,869,451,604.76 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,132,299,045.64) | (1,872,404,800.59) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 145,646,456.00 | 217,129,313.33 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (59,166,261.91) | (88,417,656.67) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 52,638,134.66 | 58,438,134.66 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (41,414,005.44) | (45,407,040.06) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 234,000,000.00 | 234,000,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,675,000.00 | 1,060,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,675,000.00) | (1,060,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 234,000,000.00 | 234,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **12,923,856,457.75** | **14,729,749,673.53** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **12,923,856,457.75** | **14,729,749,673.53** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 12,923,856,457.75 | 14,729,749,673.53 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 949,893,092.00 | 949,893,092.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 949,893,092.00 | 949,893,092.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 11,705,336,983.07 | 13,511,292,643.85 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 11,705,336,983.07 | 11,699,320,647.43 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 1,811,971,996.42 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 268,626,382.68 | 268,563,937.68 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **12,923,856,457.75** | **14,729,749,673.53** |

### Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **16,876,490,557.98** | **8,474,826,264.13** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **11,234,383,680.57** | **3,891,864,214.13** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 11,234,383,680.57 | 3,891,864,214.13 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 146,882,939.00 | 163,573,794.26 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 146,882,939.00 | 163,573,794.26 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 9,728,003,912.34 | 2,668,432,443.32 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 1,359,496,829.23 | 1,059,857,976.55 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,642,106,877.41** | **4,582,962,050.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,135,662,534.41 | 11,868,460.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 228,435,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 672,139,454.41 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 235,088,080.00 | 11,868,460.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 255,000,000.00 | 00.00 |
| 133004 | Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт | 255,000,000.00 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 4,251,444,343.00 | 4,571,093,590.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 4,251,444,343.00 | 4,571,093,590.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **6,185,402,319.55** | **6,651,650,755.51** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,185,402,319.55** | **6,651,650,755.51** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,610,139,590.52 | 6,645,761,069.51 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,136,943,985.47 | 2,477,901,210.79 |
| 210101 | Үндсэн цалин | 1,107,705,695.22 | 1,418,382,581.43 |
| 210102 | Нэмэгдэл | 827,016,773.27 | 914,150,781.73 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 78,831,552.56 | 56,627,000.89 |
| 210104 | Урамшуулал | 123,389,964.42 | 88,740,846.74 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 318,561,015.98 | 316,000,552.31 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 224,237,975.86 | 216,111,175.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 23,580,832.79 | 25,906,950.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 23,517,971.58 | 32,826,338.02 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,716,066.76 | 5,053,154.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 42,508,168.99 | 36,102,934.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 377,283,177.89 | 310,647,605.96 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 45,299,816.28 | 42,510,215.56 |
| 210302 | Түлш, халаалт | 235,123,994.40 | 240,248,694.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 59,899,367.21 | 27,888,696.00 |
| 210304 | Байрны түрээс | 36,960,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 132,926,241.20 | 167,152,872.94 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,822,518.00 | 11,691,734.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 60,395,850.00 | 77,049,354.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,366,764.20 | 14,364,048.94 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,424,200.00 | 4,013,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 49,916,909.00 | 60,034,636.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,991,761,122.62 | 1,801,354,246.84 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,811,211,731.70 | 1,684,000,782.54 |
| 210502 | Хоол, хүнс | 179,344,650.92 | 112,542,984.30 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,204,740.00 | 4,810,480.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 37,046,707.00 | 361,858,740.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 1,925,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 1,992,340.00 |
| 210604 | Урсгал засвар | 37,046,707.00 | 357,941,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,313,200.00 | 7,250,950.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,313,200.00 | 7,250,950.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,613,478.00 | 53,828,918.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,027,610.00 | 48,697,890.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 565,200.00 | 728,550.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 118,468.00 | 265,978.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 176,000.00 | 154,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 234,000.00 | 234,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 4,492,200.00 | 3,748,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 601,690,662.36 | 1,149,765,972.67 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 601,690,662.36 | 1,149,765,972.67 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 575,262,729.03 | 5,889,686.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 575,262,729.03 | 5,889,686.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 388,077,779.03 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 187,184,950.00 | 5,889,686.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **10,691,088,238.43** | **1,823,175,508.62** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 13,387,988.75 | 11,203,512.20 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 13,387,988.75 | 11,203,512.20 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -13,387,988.75 | -11,203,512.20 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **10,677,700,249.68** | **1,811,971,996.42** |

**Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **4,833,644,712.13** | **5,686,375,043.86** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **131,307,939.00** | **163,573,794.26** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 131,307,939.00 | 163,573,794.26 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 131,307,939.00 | 163,573,794.26 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 131,307,939.00 | 163,573,794.26 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,702,336,773.13** | **5,522,801,249.60** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,135,731,629.73 | 11,868,460.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 228,435,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 672,139,454.41 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 235,157,175.32 | 11,868,460.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 255,000,000.00 | 00.00 |
| 133004 | Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт | 255,000,000.00 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,311,605,143.40 | 5,510,932,789.60 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 3,311,605,143.40 | 5,510,932,789.60 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **4,764,984,161.80** | **4,928,779,086.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,764,984,161.80** | **4,928,779,086.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,189,721,432.77** | **4,922,889,400.33** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,164,871,818.21 | 2,475,406,750.21 |
| 210101 | Үндсэн цалин | 878,661,392.62 | 1,293,556,962.85 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 1,083,988,908.61 | 992,915,441.75 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 78,831,552.56 | 67,408,269.59 |
| 210104 | Урамшуулал | 123,389,964.42 | 121,526,076.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 323,930,954.98 | 316,118,963.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 229,607,911.86 | 214,932,301.32 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 23,580,835.79 | 26,231,321.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 23,517,971.58 | 21,647,380.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,716,066.76 | 5,118,169.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 42,508,168.99 | 48,189,791.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 377,283,177.89 | 311,647,605.96 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 45,299,816.28 | 43,510,215.56 |
| 210302 | Түлш, халаалт | 235,123,994.40 | 240,248,694.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 59,899,367.21 | 27,888,696.00 |
| 210304 | Байрны түрээс | 36,960,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 154,359,834.20 | 167,038,124.94 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,987,337.00 | 12,032,329.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 58,815,950.00 | 79,167,965.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,684,804.20 | 14,364,048.94 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,424,200.00 | 4,013,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 71,447,543.00 | 57,460,682.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,111,168,680.49 | 1,187,005,697.56 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 971,905,207.00 | 1,056,216,132.56 |
| 210502 | Хоол, хүнс | 130,808,473.49 | 113,648,885.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,455,000.00 | 17,140,680.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 43,904,189.00 | 404,369,890.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 16,570,989.00 | 14,963,150.00 |
| 210602 | Тавилга | 858,400.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 2,757,440.00 |
| 210604 | Урсгал засвар | 26,474,800.00 | 386,649,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,313,200.00 | 7,250,950.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,313,200.00 | 7,250,950.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,889,578.00 | 54,051,418.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,027,610.00 | 48,697,890.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 565,200.00 | 728,550.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 118,468.00 | 265,978.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 176,000.00 | 154,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 234,000.00 | 234,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 4,768,300.00 | 3,971,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **575,262,729.03** | **5,889,686.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 575,262,729.03 | 5,889,686.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 388,077,779.03 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 187,184,950.00 | 5,889,686.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **68,660,550.33** | **757,595,957.53** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **67,891,140.00** | **465,605,830.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **67,891,140.00** | **465,605,830.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 67,891,140.00 | 465,605,830.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 67,891,140.00 | 465,605,830.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-67,891,140.00** | **-465,605,830.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 769,410.33 | 291,990,127.53 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 769,410.33 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 769,410.33 | 292,759,537.86 |

**Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 949,893,092.00 | 270,729,125.14 | 385,985,843.66 | 00.00 | 1,606,608,060.80 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **949,893,092.00** | **270,729,125.14** | **385,985,843.66** | **00.00** | 1,606,608,060.80 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -28,558,452.70 | 00.00 | -28,558,452.70 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **949,893,092.00** | **268,626,382.68** | **11,705,336,983.07** | **00.00** | 12,923,856,457.75 |
| D01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **949,893,092.00** | **268,626,382.68** | **11,705,336,983.07** | **00.00** | 12,923,856,457.75 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -6,016,335.64 | 00.00 | -6,016,335.64 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **949,893,092.00** | **268,626,382.68** | **11,699,320,647.43** | **00.00** | 12,917,840,122.11 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -62,445.00 | 00.00 | 00.00 | -62,445.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,811,971,996.42 | 00.00 | 1,811,971,996.42 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **949,893,092.00** | **268,563,937.68** | **13,511,292,643.85** | **00.00** | 14,729,749,673.53 |

4417144353
ЕЮА0056 9025707

## Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 6,505,859,900.00 | 5,394,384,916.33 | 1,111,474,983.67 | 82.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 6,505,859,900.00 | 5,394,384,916.33 | 1,111,474,983.67 | 82.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,499,929,800.00 | 5,388,495,230.33 | 1,111,434,569.67 | 82.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,838,349,100.00 | 2,475,406,750.21 | 362,942,349.79 | 87.2 |
| 210101 | Үндсэн цалин | 1,281,744,000.00 | 1,293,556,962.85 | -11,812,962.85 | 100.9 |
| 210102 | Нэмэгдэл | 1,274,149,600.00 | 992,915,441.75 | 281,234,158.25 | 77.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 32,203,500.00 | 67,408,269.59 | -35,204,769.59 | 209.3 |
| 210104 | Урамшуулал | 250,252,000.00 | 121,526,076.02 | 128,725,923.98 | 48.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 354,793,700.00 | 316,118,963.66 | 38,674,736.34 | 89.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 241,259,700.00 | 214,932,301.32 | 26,327,398.68 | 89.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 28,383,500.00 | 26,231,321.34 | 2,152,178.66 | 92.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 22,706,800.00 | 21,647,380.69 | 1,059,419.31 | 95.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,676,700.00 | 5,118,169.17 | 558,530.83 | 90.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 56,767,000.00 | 48,189,791.14 | 8,577,208.86 | 84.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 421,693,300.00 | 311,647,605.96 | 110,045,694.04 | 73.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 68,003,100.00 | 43,510,215.56 | 24,492,884.44 | 64.0 |
| 210302 | Түлш, халаалт | 271,027,200.00 | 240,248,694.40 | 30,778,505.60 | 88.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 82,663,000.00 | 27,888,696.00 | 54,774,304.00 | 33.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 183,770,200.00 | 167,038,124.94 | 16,732,075.06 | 90.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,986,600.00 | 12,032,329.00 | -1,045,729.00 | 109.5 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 81,651,300.00 | 79,167,965.00 | 2,483,335.00 | 97.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,213,400.00 | 14,364,048.94 | -150,648.94 | 101.1 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 13,144,000.00 | 4,013,100.00 | 9,130,900.00 | 30.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 63,774,900.00 | 57,460,682.00 | 6,314,218.00 | 90.1 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,294,674,200.00 | 1,187,005,697.56 | 107,668,502.44 | 91.7 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,127,456,100.00 | 1,056,216,132.56 | 71,239,967.44 | 93.7 |
| 210502 | Хоол, хүнс | 150,058,700.00 | 113,648,885.00 | 36,409,815.00 | 75.7 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 17,159,400.00 | 17,140,680.00 | 18,720.00 | 99.9 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,323,277,400.00 | 869,975,720.00 | 453,301,680.00 | 65.7 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 539,060,800.00 | 403,302,930.00 | 135,757,870.00 | 74.8 |
| 210602 | Тавилга | 73,500,000.00 | 61,566,050.00 | 11,933,950.00 | 83.8 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 8,216,600.00 | 2,757,440.00 | 5,459,160.00 | 33.6 |
| 210604 | Урсгал засвар | 702,500,000.00 | 402,349,300.00 | 300,150,700.00 | 57.3 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,284,000.00 | 7,250,950.00 | 33,050.00 | 99.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,284,000.00 | 7,250,950.00 | 33,050.00 | 99.5 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 76,087,900.00 | 54,051,418.00 | 22,036,482.00 | 71.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 58,194,900.00 | 48,697,890.00 | 9,497,010.00 | 83.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,419,200.00 | 00.00 | 2,419,200.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 931,100.00 | 728,550.00 | 202,550.00 | 78.2 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 531,500.00 | 265,978.00 | 265,522.00 | 50.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 431,200.00 | 154,000.00 | 277,200.00 | 35.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,920,000.00 | 00.00 | 7,920,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 360,000.00 | 234,000.00 | 126,000.00 | 65.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 200,000.00 | 00.00 | 200,000.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 5,100,000.00 | 3,971,000.00 | 1,129,000.00 | 77.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5930100.00 | 5889686.00 | 40,414.00 | 99.3 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,930,100.00 | 5,889,686.00 | 40,414.00 | 99.3 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,930,100.00 | 5,889,686.00 | 40,414.00 | 99.3 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 6,505,859,900.00 | 5,686,534,812.18 | 819,325,087.82 | 87.4 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 5,993,363,400.00 | 5,510,932,789.60 | 482,430,610.40 | 92.0 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 5,993,363,400.00 | 5,510,932,789.60 | 482,430,610.40 | 92.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 512,496,500.00 | 175,602,022.58 | 336,894,477.42 | 34.3 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 512,496,500.00 | 163,573,794.26 | 348,922,705.74 | 31.9 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 12,028,228.32 | -12,028,228.32 | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 609,642.01 | -609,642.01 | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 292,759,537.86 | -292,759,537.86 | - |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 95.00 | 116.00 | -21.00 | 122.1 |
| 620001 | Удирдах ажилтан | 02.00 | 02.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 72.00 | 83.00 | -11.00 | 115.3 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 21.00 | 31.00 | -10.00 | 147.6 |

**Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | - | - |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | - | - |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | - | - |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | - | - |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | - | - |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | - | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - |

4417144353
БЮА0056 9025707

## 3.Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Замын үүд сумын Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэл нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэвтэн эмчлүүлэх, амбулаторийн үзлэг ,оношилгоо шинжилгээ түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлдэг.

Эрхэм зорилго: Мэргэжилтнээ дэмжиж үйлчлүүлэгчээ хүндэлсэн орчин үеийн нотолгоонд тулгуурласан чадварлаг баг эмнэлгийн тусламж үйлчилгээг хариуцлагатай ээлтэй тэгш хүртээмж үзүүлэхэд оршино.
Алсын хараа: Ес зүйг эрхэмлэсэн стандартад нийцсэн чанартай цогц үйлчилгээг үзүүлэгч хоёрдогч шатлалын эмнэлэг байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН:**
- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль;
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль;
- Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль;
- Бусад.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГО, ТОЛИЛУУЛГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,805.9 сая төгрөгөөр буюу 14.0 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 769.41 | 292,759.54 | 291,990.13 |
| Авлага | 967,399.79 | 3,530.76 | (963,869.03) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 805,296.71 | 1,310,000.03 | 504,703.33 |
| Үндсэн хөрөнгө | 11,150,390.55 | 13,123,459.34 | 1,973,068.79 |
| **Нийт хөрөнгө** | **12,923,856.46** | **14,729,749.67** | **1,805,893.22** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 12,923,856.46 | 14,729,749.67 | 1,805,893.22 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **12,923,856.46** | **14,729,749.67** | **1,805,893.22** |

Авлага дансны үлдэгдэл 3.5 сая төгрөг нь байгууллагаас авах 3.2 сая төгрөг, ажилчидтай холбогдсон 0.3 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,310.0 сая төгрөг болж өмнөх оноос 504.7 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал 422.0 сая төгрөг, тусгай зориулалттай материал 27.4 сая төгрөг, түлш шатах тослох материал 5.6 сая төгрөг, барилгын засварын материал 19.4 сая төгрөг, хүнсний материал 1.1 сая төгрөг, бусад хангамжийн материал 29.6 сая төгрөгөөр нэмэгдэж, бичиг хэргийн материал 0.4 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13,123.5 сая төгрөг болж өмнөх оноос 1,973.1 сая төгрөгөөр өссөн нь машин тоног төхөөрөмж 2,892.8 сая төгрөг, тавилга эд хогшил 71.5 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 5.8 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт 189.8 сая төгрөгийн хөрөнгө акталж, 5.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж балансаас балансад шилжүүлж, 1,149.8 сая төгрөгийн элэгдэл хорогдол тооцсон дүнгээр буурчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14,729.7 сая төгрөг болж 1,805.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 6,505.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 6,505.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,505.9 сая төгрөгийн төсөв баталснаас 5,993.4 сая төгрөгийг ЭМДС-аас, үндсэн үйл ажиллагааны орлогоос 512.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр ЭМДС-аас тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 5,510.9 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 175.6 сая төгрөг, үйл ажиллагаанд 5,394.4 сая төгрөгийг зарцуулж мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 292.8 сая төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,294.4 сая төгрөг буюу 82.9 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт, хувиар |
|---|---|---|---|---|---|
| | Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих | 5,993,363.4 | 5,510,932.8 | 482,430.6 | 92.0% |
| | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 512,496.5 | 175,602.0 | 336,894.5 | 34.3% |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 6,499,929.8 | 5,388,495.2 | 1,111,434.6 | 82.9% |
| 4 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 5,930.1 | 5,889.7 | 40.4 | 99.3% |

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлтийн харилцах дансны үлдэгдлийг тэглэж үндсэн дансанд төвлөрүүлэх ЭМЯ-ны шийдвэр гарч тус дансны орлого 12.0 сая төгрөгийг үндсэн дансанд төвлөрүүлж ажилласан байна.

#### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллагад тайлант онд тусгайлсан төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4.Аудитын тайлан

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дорноговь аймгийн Замын үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний

өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Б.Ариунбаатар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитын менежер У.Оюунтулхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорноговь аймгийн Замын үүд сумын Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 16,164.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 161.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 113.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн материаллаг байдлыг 147.4 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага дээд шатны байгууллагаас өгсөн заавар, зөвлөгөөг мөрдөж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 5,863.5 сая төгрөгийн 36 гүйлгээ, зарлагын нийт 5,794.1 сая төгрөгийн 127 ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулах 11 тушаал, шийдвэр гарсан ба системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 9 горим сорил хэрэгжүүлж, аудитын явцад 6.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, санхүүгийн тайланд 452.6 сая төгрөгийн 6 залруулга хийсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлага, 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | - | 1 | - | 100 |
| Зөвлөмж | 3 | - | 3 | - | 100 |
| **Нийт дүн** | **4** | **-** | **4** | **-** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар цалин хөлс болон зардлыг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг үзэх шаардлагатай.

## 5.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт зөрчилд 2 албан шаардлага өгч, 7 алдааг залруулсан

### 5.1 Залруулсан алдаа

1. Завсрын аудитаар бичиг хэрэг, тээвэр шатахууны 18.1 сая төгрөг, эм бэлдмэл, хоол хүнс, зөөлөн эдлэлийн 329.6 сая төгрөг, урсгалын засварын материалын 29.0 сая төгрөг, маягт бэлтгэсэн 869.5 мянган төгрөгийн нийт 377.6 сая төгрөгийн бараа материалын зарлагыг санхүүгийн тайланд тусгаж залруулав.
2. Завсрын аудитаар тус байгууллага нь тайлант хугацаанд худалдан авсан 17.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авч бүртгээгүй байсныг залруулав.
3. Завсрын аудитаар тайлант хугацаанд бий болсон 6.4 сая төгрөгийн авлага, 5.0 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг залруулсан.
4. Тайлант хугацаанд бий болсон 17.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг бодуулаагүй байсныг залруулсан.
5. Завсрын аудитаар үнэ төлбөргүй хүлээн авсан 27.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 1.1 сая төгрөгийн бараа материалыг буруу бүртгэснийг залруулав.
6. Завсрын аудитаар тайлант хугацаанд 1.1 сая төгрөгийн цэвэр бохир усны зардлыг түлш халаалтын зардалд шилжүүлэн зарцуулж СҮДТ-д буруу тайлагнасан байсныг залруулсан.
7. Нэмэлт санхүүжилтийн дансаар орсон 11.9 сая төгрөгийн орлогыг үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоор бүртгэснийг залруулав.

### 5.2 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Завсрын аудитаар тус байгууллага нь 2022 оны 3 дугаар сард ЗГ-ын 107 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг батлах тогтоолыг үндэслэн тус эмнэлгийн даргын А/13 дугаар тушаал гарсан боловч 3 дугаар сард цалинг нэмэгдүүлээгүй ба 6,672.4 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д *"ажилтны цалин хөлсийг, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно"*, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т *"Төсвийн шууд захирагч нь батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох эрхтэй"* гэж заасантай нийцэхгүй байна.

**2. Зориулалт бус зарцуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Тус байгууллага нь 2022 онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас мэдээлэл технологийн зардалд 13.5 сая төгрөг, шуудан холбооны зардал 52.5 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардлаас урсгал засварын зардалд 19.2 сая төгрөгийг, гэрэл цахилгааны зардлаас шатахууны зардалд 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулж нийт 33.7 сая төгрөгийн батлагдсан төсвийг зориулалтын бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна"* гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацааны бараа материалын зарлагыг хийгээгүй | 1 | 377,591.8 | 1 | 377,591.8 | | | 1 | 470,310.7 | | | | |
| Тайлант хугацаанд худалдан авсан хөрөнгийг орлогод авч бүртгээгүй | 1 | 17,186.6 | 1 | 17,186.6 | | | 1 | 17,186.6 | | | | |
| Авлага өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй | 1 | 11,411.7 | 1 | 11,411.7 | | | 1 | 11,411.7 | | | | |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл бодуулаагүй | 1 | 17,116.4 | 1 | 17,116.4 | | | 1 | 17,116.4 | | | | |
| Үндсэн хөрөнгө, бараа материалыг буруу бүртгэсэн | 1 | 28,182.2 | | | 1 | 28,182.2 | 1 | 28,182.2 | | | | |
| Тогтмол зардлыг зардал хооронд зарцуулахдаа СҮДТ-д буруу тусгасан | 1 | 1,135.4 | | | 1 | 1,135.4 | 1 | 1,135.4 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Орлого буруу бүртгэсэн | 1 | 11,868.5 | | | 1 | 11,868.5 | 1 | 11,868.5 | | | | |
| **Дүн** | **7** | **464,492.5** | **4** | **423,306.4** | **3** | **41,186.1** | **7** | **464,492.5** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

**/мянган төгрөгөөр/**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 33,697.5 | - | - | 1 | 33,697.5 | - | - | - | - |
| Цалин хөлсийг дутуу олгосон | 1 | 6,672.4 | | | 1 | 6,672.4 | | | | |
| **Дүн** | **2** | 40,369.9 | - | - | **2** | 40,369.9 | - | - | - | - |